

ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ ПҮРЭВЧУЛУУНЫ АРИУНТУУЛЫН
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт							
Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. “ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ 2024 ОНЫ ГАДААД АЙЛЧЛАЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨГ БАТЛУУЛЖ, ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАН АЖИЛЛАНА.”							
1.	Арга хэмжээ 1.1 Цахим хөгжил, харилцаа холбооны яамны 2024 оны гадаад айлчлал, арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, батлуулна.	Батлагдсан баримт бичгийн тоо	-	1	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны 2024 оны гадаад арга хэмжээний төлөвлөгөөг 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан.	01-03	100
2.	Арга хэмжээ 1.2. Цахим хөгжил, харилцаа холбооны яамны 2024 оны гадаад айлчлал, арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиглана.	Хэрэгжилт гаргасан эсэх	-	1	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны 2024 оны гадаад арга хэмжээний төлөвлөгөөний хагас жил, жилийн эцсийн хэрэгжилтийг гарган, Төрийн нарийн бичгийн даргад танилцуулсан.	01-12	100
Зорилт 2. “САЙД, ДЭД САЙД, ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА БОЛОН ЯАМНЫ ХЭМЖЭЭНД АЛБАН БОЛОН АЖЛЫН АЙЛЧЛАЛ, ГАДААД ТОМИЛОЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛНА.”							
3.	Арга хэмжээ 2.1. Сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн даргын	Зохихон байгуулсан эсэх Тийм-1, Үгүй-0	13	6	1.Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал 2024 оны 01 дүгээр сарын 25-наас 02 дугаар сарын 01-ний өдөр Америкийн	01-12	100

албан болон ажлын айлчлал, гадаад томилголыг зохион байгуулна.				Нэгдсэн Улсад ажлын айлчлал хийв. Айлчлалын бүрэлдэхүүнд Монгол Улсын харилцаа холбоо, мэдээллийн технологи, сансрын салбарын нийт 50 орчим компанийн удирдлага оролцов. Айлчлалын хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал тэргүүтэй төлөөлөгчид АНУ-ын төр, хувийн хэвшлийн төлөөлөгчидтэй нийт 34 уулзалт хийж хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааг сансар, цахим эдийн засаг, хиймэл оюун ухааны чиглэлээр өргөжүүлэн хөгжүүлэх асуудлаар санал солилцов. Вашингтон, Сан Франциско хотноо Хурдан цэгийн нээлт, Цахиурын хөндий дэх Монгол иргэдтэй уулзалт, Торгоны зам инновацийн төвийн нээлт зэрэг арга хэмжээг зохион байгуулав. 2.Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал 2024 оны 02 дугаар сарын 12-14-ний өдөр Дубай хотноо зохион байгуулагдсан “Дэлхийн Засгийн газруудын дээд түвшний уулзалт”-д Монгол Улсын Засгийн газрыг төлөөлөн урилгаар оролцов. Дээд түвшний уулзалтын хүрээнд зохион байгуулагдсан “Government Digital Transformation: The Road Ahead” болон “Digital Government: a Dream for Some and a Reality for others” сэдэвт хэлэлцүүлэгт тус тус оролцож, Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй цахим хөгжлийн бодлого, үйл ажиллагаа, үр дүнгийн талаар дэлгэрэнгүй танилцуулав. Сайд Н.Учрал 02 дугаар сарын 13-ны өдөр АНЗУ-ын Засгийн газрын гишүүн, Хиймэл оюун ухаан, цахим эдийн засаг, зайны хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн Төрийн сайд Омар Султан Аль-Олама-тай хоёр талын уулзалт хийж, Монгол, АНЗУ-ын хооронд Хиймэл оюун ухааны салбарт хамтран ажиллах		
---	--	--	--	--	--	--

				санамж бичиг байгуулав. Мөн 02 дугаар сарын 14-ний өдөр “Дэлхийн Засгийн газруудын дээд түвшний уулзалт”-ын хүрээнд Арабын Нэгдсэн Эмират Улсын Засгийн газраас олгодог нэр хүндтэй шагнал болох “Global Government Excellence Award” шагналыг гардуулах ёслолын арга хэмжээнд оролцож, “Digital Governance Transformation” төрлийн шилдэг Засгийн газрын шагналыг Монгол Улсын Засгийн газрыг төлөөлөн гардан авав. 3.Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Сөүл хотноо 2024 оны 03 дугаар сарын 18-20-ны өдөр зохион байгуулагдах “Хиймэл оюун ухаан-Дижитал технологи ба Ардчилал” сэдэвт Сайд нарын бага хуралд оролцов. Сайд Н.Учрал арга хэмжээний хүрээнд АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Энтони Блинкен, Британи Улсын Шадар сайд Оливер Доуден, Эстони Улсын Эдийн засаг, харилцаа холбооны сайд Тийт Рийсало зэрэг албан тушаалтнууд болон “Meta” компанийн Аюулгүй байдлын бодлогын газрын захирал Нэтэниэл Глийшер зэрэг хувийн хэвшил, иргэний нийгмийн төлөөллүүдтэй товч уулзаж, дижитал технологи, хиймэл оюун ухаан, төрийн цахим үйлчилгээний чиглэлээр хамтран ажиллах боломж, дижиталчлалын эрин үед улс орнууд технологийн дэвшлийг ардчиллыг бэхжүүлэх, хүний эрхийг хамгаалах, нээлттэй, шударга нийгмийг цогцлооход үр дүнтэй ашиглах, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэхийн ач холбогдлыг онцлон тэмдэглэв. Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Сөүл хотноо ажиллах үеэр 03 дугаар сарын 19-ний өдөр Бүгд Найрамдах Солонгос		
--	--	--	--	--	--	--

				Улсын Шинжлэх ухаан, мэдээлэл, харилцаа холбооны технологийн сайд И Жун Ху-тай хоёр талын уулзалт хийж, Монгол Улсын Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Шинжлэх ухаан, мэдээлэл, харилцаа холбооны технологийн яам хооронд “Мэдээлэл, харилцаа холбооны салбарт хамтран ажиллах тухай Харилцан ойлголцлын санамж бичиг”-г гарын үсэг зурав. 4.Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг тэргүүтэй төлөөлөгчид Испанийн Хаант Улсын Барселон хотноо 02 дугаар сарын 26-29-ний өдөр зохион байгуулагдсан “Дэлхийн үрэн холбооны конгресс 2024”-д оролцов. Энэ үеэр Монгол Улсын Павильоныг ажиллуулж, Монголын Улсын цахим шилжилт, мэдээллийн технологийн салбарын дэвшилийг сурталчлав. Мөн зохион байгуулагч талтай хоёр талын уулзалт хийж, цаашдын хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов. 5.Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг АНУ-ын Вашингтон хотноо 03 дугаар сарын 05-06-ны өдөр зохион байгуулагдсан “Global Digital Summit” арга хэмжээнд оролцож, Монгол Улсын цахим шилжилт, төрийн үйлчилгээг цахимжуулсан туршлага, үр дүнгийн талаар танилцуулга хийв. Мөн Дэлхийн банкны төлөөлөлтэй хоёр талын уулзалт хийв. 6. Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг Ази, Номхон Далайн Цахилгаан Холбооны байгууллагаас Япон Улсын Токио хотноо 2024 оны 05 дугаар 27-ноос 30-ны өдрүүдэд зохион байгуулсан “Бодлого төлөвлөлт, боловсруулалтын чиглэлээр дээд түвшний албан хаагчдад зориулсан семинар”-г		
--	--	--	--	---	--	--

				оролцож, Монгол Улсын харилцаа холбооны дэд бүтцийн өнөөгийн байдал, дижитал дэд бүтцийн бодлого, цахим шилжилтийн стратеги болон хэрэгжилтийн талаар танилцуулж, Ази, Номхон далайн бүсийн орнуудтай туршлага солилцов. 7. Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг Гадаад харилцааны сайдын Америкийн Нэгдсэн Улсад хийсэн албан ёсны айлчлалын бүрэлдэхүүнд 2024 оны 07 дугаар сарын 19-нөөс 26-ны өдрүүдэд ажиллав. Айлчлалын үеэр Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улс хоорондын Стратегийн яриа хэлэлцээнд оролцож, АНУ-ын Үндэсний сансрын зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн даргатай уулзаж, хамтын ажиллагааны чиглэлээр санал солилцов. 8. Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од “Дэлхийн сансрын бизнесийн долоо хоног арга хэмжээ” болон Монгол Улсын “Үндэсний хиймэл дагуул” хөтөлбөрийн хүрээнд холбогдох уулзалтад оролцохоор 2024 оны 09 дүгээр сарын 15-наас 21-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Франц Улсад албан томилолтоор ажиллав. 9. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүг Монгол Улсын Ерөнхий сайдын Бүгд Найрамдах Хятад Ард Улсад хийх ажлын айлчлалын бүрэлдэхүүнд 2024 оны 11 дүгээр сарын 04-нөөс 07-ны өдрүүдэд ажиллаж, “Хятадын Олон улсын импортын долдугаар экспо”-той танилцав. 10. Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од Бүгд Найрамдах Эстони Улсын Таллин хотноо цахим засаглал, цахим шилжилтийн		
--	--	--	--	--	--	--

				талаар туршлага судлах, хамтын ажиллагааны чиглэлээр санал солилцохоор 2024 оны 11 дүгээр сарын 23-наас 28-ны өдрүүд албан томилогтгоор ажиглав.		
--	--	--	--	--	--	--

Зорилт 3. “ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА, ГАДААД УЛСЫН БАЙГУУЛЛАГАТАЙ ГЭРЭЭ, ХЭТЭЛЦЭЭРИЙН БАЙУУЛАХ БЭЛТТЭЛИЙГ ХАНГАНА.”

					1.Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон Арабын Нэгдсэн Эмират Улсын Ерөнхий сайдын дэргэдэх Хиймэл оюун ухааны газар хооронд байгуулах Харилцан ойлголцлын санамж бичгийг төслийг боловсруулж, англи-монгол хэлнээ орчуулж, айлын талтай эцэслэн тохирсон төслийг Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулсан. ЦХХХ-ны сайд Н.Учрал 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдөр АНЭУ-ын Засгийн газрын гишүүн, Хиймэл оюун ухаан, цахим эдийн засаг, зайны хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн Төрийн сайд Омар Султан Аль-Олама-тай Дубай хотноо уулзах үеэр тус Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурж баталгаажуулсан.		
4.	Арга хэмжээ 3.1. Олон улсын байгууллага, гадаад улсын байгууллагатай гэрээ, хэлэлцээрийг төсөлд санал авах, орчуулах, айлын талтай эцэслэн тохирах, Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулна.	Бэлтгэл хангасан ажлын хэрэгжилтээр Тийм-1, Үгүй-0	3	1	2.Монгол Улсын Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Шинжлэх ухаан, мэдээлэл, харилцаа холбооны технологийн яам хооронд "Мэдээлэл, харилцаа холбооны салбарт хамтран ажиглах тухай Харилцан ойлголцлын санамж бичиг"-ийн айлын талтай эцэслэн тохирсон төслийг Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулсан. ЦХХХ-ны сайд Н.Учрал 2024 оны 3 дугаар сарын 19-ний өдөр Бүгд Найрамдах Солонгос Улсын Шинжлэх ухаан, мэдээлэл,	01-12	100

					харилцаа холбооны технологийн сайд И Жун Ху-тай Сөүл хотноо уулзах үеэр тус Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурж баталгаажуулсан. 3.Монгол Улсын Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон Бүгд Найрамдах Колумби Улсын Мэдээлэл, харилцаа холбооны технологийн яам хоорондын цахим засаглалын чиглэлээр хамтран ажиллах Харилцан ойлголцлын санамж бичиг"-ийн айлын талтай эцэслэн тохирсон төслийг Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулж бэлтгэсэн. Цахимаар гарын үсэг зурах ажил хүлээгдэж байна. 4. Монгол Улс болон Оросын Холбооны Улсын харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн байгууллага хооронд хил орчмын бүс нутагт ашиглах радио давтамжийн зохицуулалтын гэрээ, хэлэлцээ хийх ээлжит уулзалт 2024 оны 04 дүгээр сарын 09-11-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулав. Тус уулзалтын үеэр радио давтамжийн 29.7-470 МГц, 450 МГц, 150 МГц, 700 МГц зурваст газрын хөдөлгөөнт болон 29.7-39.5 МГц зурваст газрын хөдөлгөөнт бүс үйлчилгээний зохицуулалтын асуудлуудыг хэлэлцэн нийт 4 гэрээг шинээр байгуулахаар тогтсон бөгөөд манай талаас албажуулсан гэрээнүүдийг хувийг Монгол улсаас Оросын Холбооны Улсад суугаа Элчин сайдын яамаар дамжуулан уламжлуулахаар 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 03/372 дугаартай албан бичгээр Гадаад харилцааны яаманд		
--	--	--	--	--	---	--	--

					хүргүүлсэн. Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суугаа Элчин сайдын яам 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн Төлөөний ноот бичгээр Оросын Холбооны Улсын Гадаад харилцааны яаманд уламжилсан талаар мэдэгдсэн. 5. Монгол Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн байгууллага хооронд хил орчмын бүс нутагт ашиглах радио давтамжийн зохицуулалтын гэрээ, хэлэлцээ хийх ээлжит уулзалт 2024 оны 05 дугаар сарын 21-23-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулав. Тус уулзалтын үеэр радио давтамжийн 1920-1965/2110-2155 МГц зурваст газрын хөдөлгөөнт холбооны үйлчилгээний зохицуулалтын 1 гэрээг шинээр байгуулав. 6. Монгол Улсын Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам болон Бүгд Найрамдах Казахстан Улсын Цахим хөгжил, инновац, сансрын аж үйлдвэрийн яам хооронд инновац, мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарт хамтран ажиллах Харилцан ойлголцлын санамж бичгийн төслийг шинэчлэн боловсруулж, айлын талтай эцэслэн тохиролцсон төслийг Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулж бэлтгэсэн. Уг санамж бичгийн Бүгд Найрамдах Казахстан Улсын Ерөнхийлөгчийн Монгол Улсад хийсэн төрийн айлчлалын үеэр 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдөр гарын үсэг зурж баталгаажуулсан.		
--	--	--	--	--	---	--	--

Зорилт 4. “МОНГОЛ УЛСЫН ГИШҮҮНЧЛЭЛ БҮХИЙ МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРЫН ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛНА.”							
5.	Арга хэмжээ 4.1. Гишүүнчлэл бүхий олон улсын байгууллагаас зохион байгуулах сургалт, арга хэмжээнд тэтгэлгээр оролцох хүсэлтийг баталгаажуулж хүргүүлнэ.	Тэтгэлэг хүссэн арга хэмжээний тоо	0	10	Тайлант хугацаанд нийт 31 арга хэмжээнд оролцох 39 албан хаагчийн тэтгэлэгээр оролцох хүсэлтийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. 24 албан хаагч тэтгэлэг авч арга хэмжээнд амжилттай оролцсон. 1 албан хаагч тэтгэлэг авсан боловч эрүүл мэндийн шалтгаанаар арга хэмжээнд оролцохоос татгалзсан.	01-12	100
6.	Арга хэмжээ 4.2. Гишүүнчлэл бүхий олон улсын байгууллагаас зохион байгуулах сургалт арга хэмжээнд оролцуулна.	Оролцсон арга хэмжээний тоо	29	15	Тайлант хугацаанд тус яамны нийт давхардсан тоогоор 74 албан хаагчийг 17 улсад зохион байгуулагдсан 52 арга хэмжээнд оролцоход дэмжлэг үзүүлж ажилласан. Үүнд: 1.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Сансрын асуудал эрхэлсэн алба /UNOOSA/ болон НҮБ-ын Их сургуулиас хамтран Япон Улсын Токио хотноо зохион байгуулсан “Ази Номхон далайн орнуудын Сансрын хуулийн зөвлөгөөн”-д 1 алба хаагч; 2.Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралын Америкийн Нэгдсэн Улсад хийх ажлын айлчлалын бүрэлдэхүүнд 7 албан хаагч; 3.Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллагаас зохион байгуулсан “Харилцаа холбоо, мэдээллийн технологийн төслийн төлөвлөлтийн чадавх бэхжүүлэх” сургалтад 1 албан хаагч; 4.БНКУ-ын Цахим хөгжил, инноваци, сансрын аж үйлдвэрийн яамнаас зохион байгуулсан “Дижитал Алматы 2024”-д 3 албан хаагч; 5. “Дэлхийн үүрэн холбооны конгресс 2024” арга хэмжээнд 3 албан хаагч;	01-12	100

					6.Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллагаас зохион байгуулсан “Кибер аюулгүй байдлын хүний нөөцийг чадавхжуулах” сэдэвт сургалтад 2 албан хаагч; 7.Оросын Холбооны Улсын Цахим хөгжил, харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн яамнаас зохион байгуулсан “Евроазийн мэдээллийн технологийн анхдугаар форум”-д 3 албан хаагч; 8.Дэлхийн Банкаас зохион байгуулсан “Дэлхийн цахим чуулган”-д 1 албан хаагч; 9.Карнеги Меллон Их сургуулийн Технологийн бодлогын удирдлагын төвөөс Руанда Улсад зохион байгуулсан “Цахим худалдаа: Дижитал эдийн засгийн олон улсын худалдааны дүрэм, экосистем ба дижитал өөрчлөлт” сэдэвт сургалтад 1 албан хаагч; 10.АНДЦХБ-аас Тайландын Хаант Улсад зохион байгуулсан “Утасгүй холбооны багийн 32 дугаар уулзалт”-д 1 албан хаагч; 11.БНСУ-ын Гадаад харилцааны яамнаас зохион байгуулсан “Ардчиллын төлөөх Дээд түвшний уулзалт”-д 1 албан хаагч; 12.Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Худалдааны яамнаас зохион байгуулсан “Цахим худалдаа” сэдэвт сургалтад 2 албан хаагч; 13. Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкттай хамтран тус улсын Астана хотноо Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулсан “Цахим худалдааны хоёрдугаар форум”, “Бүс нутгийн худалдааны ажлын хэсгийн зургаадугаар уулзалт”, “Цахим хөгжлийн үзэсгэлэн болон туршлага судлах арга хэмжээ”, “Цахим стратегийн удирдах		
--	--	--	--	--	--	--	--

					хорооны хоёрдугаар уулзалт"-д 1 албан хаагч; 14. Ази, Номхон далайн цахилгаан холбооны байгууллагаас Тайландын Хаант Улсад зохион байгуулсан "Олон улсын хуралд бэлтгэх нь" сэдэвт сургалтад 1 албан хаагч; 15. Ази, Номхон далайн сансрын хамтын ажиллагааны байгууллагаас БНХАУ-д зохион байгуулсан тус байгууллагын "Хөгжлийн төлөвлөгөөний хорооны уулзалт"-д 2 албан хаагч; 16. Олон Улсын Цахилгаан Холбооны Байгууллагаас БНХАУ-д зохион байгуулсан "3-р бүсийн орнуудад зориулсан Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтийн семинар"-т 1 албан хаагч; 17. Ази, Номхон Далайн Цахилгаан Холбооны Байгууллагаас БНХАУ-д зохион байгуулсан "Дэлхийн радио холбооны их хурал (MRS27)-д бэлтгэх Ази, Номхон Далайн бүсийн нэгдүгээр бэлтгэл хурал"-д 1 албан хаагч; 18. АНУ-ын Төрийн департаментас БНСВУ-д зохион байгуулсан "AI Connect II" хөтөлбөрийн Азийн бүсийн сургалт, хэлэлцүүлэгт 1 албан хаагч; 19. Ази, Номхон далайн цахилгаан холбооны байгууллага болон БНСУ-ын Мэдээллийн нийгмийн агентлагтай хамтран зохион байгуулсан чадваржуулах хөтөлбөрт 1 албан хаагч; 20. Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас зохион байгуулсан "Кибер халдлагаас хамгаалах дадлага" сэдэвт сургалтад 1 албан хаагч; 21. Нэгдсэн Үндэстний Байгууллагаас зохион байгуулсан "Олон улсын аюулгүй		
--	--	--	--	--	---	--	--

					байдал ба кибер орон зай дахь эмэгтэйчүүд” сэдэвт сургалтад 1 албан хаагч; 22. БНСУ-ын Кибер аюулгүй байдлын хөгжлийн холбооноос зохион байгуулсан тус холбооны 9 дүгээр уулзалтад 1 албан хаагч; 23. Ази, Номхон далайн цахилгаан холбооны байгууллагаас Тайландын Хаант Улсад зохион байгуулсан “Хэт богино долгионы сүлжээний технологи ба шийдэл” сэдэвт сургалтад 1 албан хаагч; 24. Ази, Номхон далайн цахилгаан холбооны байгууллагаас БНЭУ-д зохион байгуулсан “Тоон хуваагдлын бодлого, төлөвлөлт” сэдэвт сургалтад 1 албан хаагч; 25. БНСУ-ын дотоод хэрэг, аюулгүй байдлын яам болон үндэсний мэдээллийн нийгмийн агентлагаас зохион байгуулсан “2024 Дижитал засгийн газрын бодлогын менежмент сургалт” сэдэвт сургалтад 1 албан хаагч; 26. НҮБ-ын Ази Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс, БНКУ-ын Цахим хөгжил инновац, сансрын аж үйлдвэрийн яам хамтран зохион байгуулсан “Цахим оролцоо ба цахим шилжилт” сэдэвт бага хуралд 1 албан хаагч; 27. НҮБ-ын худалдаа хөгжлийн байгууллагаас БНХАУ-д зохион байгуулсан “Шинжлэх ухаан технологи инновацын паркийн бодлого, туршлага” сэдэвт семинарт 1 албан хаагч; 28. Ази, Номхон далайн сансрын хамтын ажиллагааны байгууллагын “Админ байгууллагуудын зөвлөлдөх уулзалт”-д 1 албан хаагч; 29. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Худалдааны яамнаас зохион байгуулсан	
--	--	--	--	--	--	--

“Цахим худалдаа” сэдэвт сургалтад 3 албан хаагч; 30. Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас зохион байгуулсан “Кибер аюулгүй байдлын олон улсын хууль эрх зүй, бодлого” сэдэвт сургалтад 1 албан хаагч; 31. Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөрөөс БНХАУ-д зохион байгуулсан “Хиймэл оюун ухаанд суурилсан цахим шилжилт” сэдэвт семинарт 1 албан хаагч; 32. БНСУ-ын шинжлэх ухаан, мэдээлэл, харилцаа холбооны технологийн яам болон Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих үндэсний агентлагаас зохион байгуулсан “Хиймэл оюун ухаанд суурилсан зүйлсийн интернэт /IoT” сэдэвт сургалтад 1 албан хаагч; 33. Ази, Номхон далайн цахилгаан холбооны байгууллагаас Япон Улсад зохион байгуулсан “Хөдөө орон нутагт тоон хуваагдлыг бууруулахад чиглэсэн сүлжээний төлөвлөлтийн үндсэн үр чадаврыг хөгжүүлэх нь” сэдэвт сургалтад 1 албан хаагч; 34. Нэгдсэн Үндэстний Байгууллагаас БНСУ-д зохион байгуулсан “Тогтвортой хөгжилд үзүүлэх Хиймэл оюун ухааны нөлөө” сэдэвт хуралд 1 албан хаагч; 35. НҮБ-ын Ази Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссоос БНХАУ-д зохион байгуулсан “Зүүн Хойд Азийн огсн талт эрсдлийн үнэлгээ болон эрт сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлэх нь” сэдэвт семинарт 1 албан хаагч; 36. Азийн Төрийн албаны холбооноос Индонези Улсад зохион байгуулсан																																
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

					"Дэлхийн жилишт нийцсэн төрийн алба" сэдэвт хурал 1 албан хаагч; 37. Ази, Номхон далайн сансрын хамтын ажиллагааны байгууллагаас АНЭУ-д зохион байгуулсан "Сансрын холбооны хөгжил, Бүс нутгийн тэнцвэр ба сорилт" сэдэвт хуралд 1 албан хаагч; 38. "Хятадын Олон улсын импортын долдугаар экто"-д 1 албан хаагч; 39. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Худалдааны наминаас зохион байгуулсан "Цахим худалдаа" сэдэвт сургалтад 4 албан хаагч; 40. Ази, Номхон далайн цахилгаан холбооны байгууллагаас зохион байгуулсан "Радио давтамжийн зурвасыг үр ашигтай ашиглах төлөвлөгт ба утасгүй холбооны технологийн чиг хандлага" сэдэвт сургалтад 1 албан хаагч; 41. Олон улсын цахилгаан холбооны байгууллагаас Брюней Улсад зохион байгуулсан "Ази, Номхон далайн бүсийн кибер дадлага суртуллигт 2024" арга хэмжээнд 1 албан хаагч; 42. НҮБ-ын Ази Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссоос БНСУ-д зохион байгуулсан "Цахим манлайгллын хөлөгбөр"-т 1 албан хаагч; 43. Нэгдсэн Үндэстний Байгууллагаас АНУ-д зохион байгуулсан "Олон улсын аюулгүй байдал ба кибер орон зай дахь эмэгтэйчүүд" сэдэвт сургалтад 1 албан хаагч; 44. Олон улсын цахилгаан холбооны байгууллагаас АНЭУ-д зохион байгуулсан "Квантум кибер аюулгүй байдал" сэдэвт хуралд 1 албан хаагч; 45. Бүгд Найрамдах Эстоли Улсын Цахим засаглалын академиас зохион байгуулсан
--	--	--	--	--	--

					цахим засаглал, цахим шилжилтийн туршлага судлах хөтөлбөрт 2 албан хаагч; 46. БНСУ-ын шинжлэх ухаан, мэдээлэл, харилцаа холбооны технологийн яамнаас зохион байгуулсан “Диамонд” клубын анхдугаар уулзалт”-д 1 албан хаагч; 47. Нэгдсэн Үндэстний Байгууллагаас Саудын Арабын Хаант Улсад зохион байгуулсан “Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцын талуудын 16 дугаар бага хурал”-д 1 албан хаагч; 48. Ази, Номхон далайн сансрын хамтын ажиллагааны байгууллагаас БНХАУ-д зохион тус байгууллагын “Удирдах зөвлөлийн 18 дугаар хуралдаан”-д 1 албан хаагч; 49. Олон улсын цахилгаан холбооны байгууллагаас Швейцарын Холбооны Улсад зохион байгуулсан “Дэлхийн Радио холбооны семинар 2024”-д 2 албан хаагч; 50. “БРИКС-ийн мэдээллийн технологи ба цахим шилжилтийн хүний нөөцийн сургалт”-д 1 албан хаагч; 51. Ази, Номхон далайн цахилгаан холбооны байгууллагаас Япон Улсад зохион байгуулсан “Ази, Номхон далайн цахилгаан холбооны байгууллагын стандартчиллын хөтөлбөр, Стандартчиллын чиглэлээр шинээр гарч ирж буй технологийн чиг хандлагыг хуваалцах нь” сэдэвт сургалтад 1 албан хаагч; 52. Нэгдсэн Үндэстний Байгууллагаас Япон Улсад зохион байгуулсан “Эмэгтэйчүүд, Технологи, Энх тайван” сэдэвт семинарт 1 албан хаагч тус тус оролцсон.		
--	--	--	--	--	---	--	--

Зорилт 5. “МОНГОЛ УЛСЫН ГИШҮҮНЧЛЭЛ БҮХИЙ ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ТАТВАР, ХУРААМЖИЙГ ТӨЛӨХ БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГАНА.”

7.	Арга хэмжээ 5.1. Гишүүнчлэл бүхий олон улсын байгууллагуудын татвар хураамжийн тооцооллын дагуу батлуулна.	Тушаалын тоо	2	0	Монгол Улсын гишүүнчлэл бүхий мэдээлэл, харилцаа холбооны салбарын 5 олон улсын байгууллагуудын гишүүнчлэлийн татвар, холбогдох бусад зардлын төсвийг Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/142 дугаартай тушаалаар баталж, СХОХ-т шилжүүлсэн.	01-06	100
8.	Арга хэмжээ 5.2. Батлагдсан төсвийн хүрээнд татвар хураамж төлөх бэлтгэл ажлыг хангана.	Гишүүнчлэлийн татвар төлсөн байгууллагын тоо	6	0	Батлагдсан тушаалын дагуу Гадаад гүйлгээний маягтыг 3 байгууллагын гишүүнчлэлийн татварын төлбөрийн хүсэлтийг бэлтгэн 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн төлбөрийн хүсэлтээр баталгаажуулсан. 2023 онд 2 байгууллагын 2024 онд хамаарах гишүүнчлэлийн татварыг төлсөн бөгөөд Сангийн яамнаас тавьсан хоригийн дагуу ОХУ-д төвтэй 1 олон улсын байгууллагын гишүүнчлэлийн татвар төлөгдөөгүй.	01-12	100

Зорилт 6. “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАНА.”

1.	Арга хэмжээ 6.1. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу албан бичиг боловсруулна, шийдвэрлэнэ.	Боловсруулсан, шийдвэрлэсэн албан бичгийн тоо	120, 49	30, 20	Тайлант хугацаанд ирсэн 54 албан бичгийг шийдвэрлэж, монгол хэлээр 44, англи хэл дээр 50 албан бичгийг боловсруулсан.	01-12	100
2.	Арга хэмжээ 6.2. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад заасан баримт бичгийг архивд хүлээлгэн өгнө.	Архивд өгсөн баримт бичгийн тоо	-	2	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтаар батлагдсан Гадаад орнуудтай байгуулсан байгууллага хоорондын гэрээ, хэлэлцээр, санамж бичгийн 2022, 2023 оны баримт бичиг, Сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн даргын гадаад улсын элчин сайд, олон улсын байгууллагын төлөөлөгчидтэй хийсэн уулзалтын тэмдэглэл, 2023 онд Гадаад албан тоймлолтоор ажигласан	01-12	100

				албан хаагчдын тайлан нийт 5 боть хүлээлгэн өгсөн.	
--	--	--	--	---	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Гаднын байгууллага болон дотооддоо зохион байгуулсан сургалтад хамрагдана.	Сургалтад хамрагдсан тоо	2	1	Сангийн яамнаас зохион байгуулсан Г адаадын зээл, тусламжийн удирдлага, зохицуулалт сэдэвт 1 өдрийн сургалтад 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдөр хамрагдаж, "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам"-ын нэмэлт өөрчлөлтийн талаарх мэдээлэлтэй танилцсан.	01-06	100
2.	Арга хэмжээ 2. Удирдлагын академис зохион байгуулах Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх урт, богино хугацааны сургалтад хамрагдана.	Сургалтад хамрагдсан тоо	-	1	Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад амжилттай суралцаж, 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдөр R2025 дугаартай сертификат авсан.	01-06	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

ГХАХ-ийн шинжээч
(Албан тушаал)

П.Ариунтуул / /
(Нэр, гарын үсэг)

Овоо / 12 / 04
(Огноо)